



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ
АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД

**МОНГОЛ УЛСЫН
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМ**

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,
Барилгачдын талбай 3, Засгийн газрын XII байр,
Утас: 31 06 12, 7600 3333-1120, Факс: (076-11) 32 29 04,
И-мэйл: info@mcud.gov.mn, Вэбсайт: www.mcud.gov.mn

2020.03.04 № 03/819

танай _____-ны № _____-т

Судалгаанд хамрагдах тухай

Монгол Улсын барилгын салбарын бүтээн байгуулалтын 94.4 хувийг ба жилдээ нийт 3.566,0 тэрбум төгрөгийн ажлыг хувийн хэвшлийн компаниуд гүйцэтгэж байна. Эдгээр аж ахуйн нэгжүүдэд 2018 оны жилийн эцсийн байдлаар 76.6 мянган ажилчид хөдөлмөр эрхэлж байснаас 2.9 мянган гадаад ажиллах хүчин ажилласан байна.

Иймд Засгийн газрын 2019 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 70 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого”-д барилгын салбарын мэргэжлийн сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох, шинэчлэх замаар сургалтын чанарыг дээшлүүлж, салбарын хүний нөөцийг нэмэгдүүлэх, чадавхжуулах арга хэмжээ авч зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажиллахаар тусгасан. Мөн дотоодын ажиллах хүчин, аж ахуйн нэгжүүдийг чадавхжуулахад дэмжих бодлого, чиглэлийг баримтлан ажиллаж байна.

Энэ хүрээнд зайлшгүй шаардлагын үндсэн дээр тус яам нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт, “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ, салбарын мэргэжлийн холбоодтой хамтран “Барилгын салбарын ажиллах хүчний эрэлтийг тодорхойлох онлайн судалгаа”-г улсын хэмжээнд зохион байгуулж байна.

Энэхүү судалгааг явуулж, мэдээллийн сан бүрдүүлснээр барилгын салбарын ажиллах хүчний өнөөгийн байдал, ирэх жилд хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчний эрэлтийг ажил мэргэжил, үйл ажиллагааны чиглэл, байршлаар нь гаргах болно. Судалгаанд барилгын салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуйн нэгж байгууллагыг хамруулж, нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх юм.

Ийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг ашиглан барилгын салбарын сургалт, хүний нөөцийн талаар төрөөс баримтлах бодлого, чиглэлийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн тодорхойлж хэрэгжүүлэх, аж ахуйн нэгжүүд болон бусад хэрэглэгчдийг энэ талын мэдээллээр хангах ач холбогдолтой юм.

Мөн аж ахуйн нэгжүүд судалгааны тайлан, мэдээллийн нэгдсэн санг ашигласнаар өөрийн компанийн хүний нөөцийг дотоодоос хангах, мэргэшүүлэн тогтвортой ажиллуулж, компанийн үр ашгийг дээшлүүлэх болон төр хувийн хэвшлийн түншлэл, харилцаа, хамтын ажиллагааг сайжруулахад чухал түлхэц үзүүлнэ гэж үзэж байна.

Иймд барилгын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэн, бригад Та бүхэн 2020 оны 03 дугаар сарын 20-ны дотор багтаан gilsp.gov.mn/barilga вебсайтаар нэвтэрч бүртгүүлэн, судалгаанд идэвхтэй оролцохыг урьж байна.

151051015

Аливаа мэдээллийн нууцыг Монгол Улсын Статистикийн тухай хууль, Байгууллагын нууцын тухай хуульд заасны дагуу хадгалж бусдад задруулахгүй байх тул програмд мэдээллээ үнэн зөв оруулахыг хүсье.

Судалгаатай холбоотой мэдээлэл, асуултыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт (77121286, 88002247, 99089216) утсаар лавлана уу.

Танай ажилд амжилт хүсье.

Хүндэтгэсэн,

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



С.МАГНАЙСҮРЭН